



“Бридж констракшн” ХХК

**“ИВЭН ГОЛ УСЛАЛТЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2022 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧИН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Улаанбаатар. 2022 он

**БАРИЛГЫН АЖЛЫН ГЭРЭЭТ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЖИЛИЙН
ТАЙЛАН БАЙГАЛЬ ОРЧИН**

2022 оны гүйцэтгэл

Гэрээт гүйцэтгэгчийн нэр: “БРИДЖ КОНСТРАКШН” ХХК

Байгаль орчны ажилтан /овог нэр, утас, цахим хаяг/: Байгаль орчны зөвлөх Л.Долгормаа Утас: 99132958,
dolgormaa-ehc@live.com

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНТ СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА “ИВЭН ГОЛЫН УСЛАЛТЫН СИСТЕМ”
ТӨСЛИЙНБАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН.**

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Төслөөс үзүүлж болзошгүй нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ /Гүйцэтгэл/	Баримтлах хууль эрх зүйн баримт бичиг
1	Материал тээвэрлэх болон бусад үйл ажиллагааны үед тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгөөнөөр агаарт тоосжилт үүсэх	Хуурай гандуу цаг агаартай үед зам талбайг услан тоосжилтыг бууруулж байх	Хэт хуурайшилтай үед зам талбайн харгдах орчин хязгаарлагдах нөхцөлд усалгаа хийж тоосжилтыг дарж байсан.	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
2		Барилгын ажилд стандартын дагуу сайтар угааж шигшсэн элс, хайрга, дайрга ашиглах	Зохих стандартын хайрга дайрга ашиглаж байна. Дархан-Уул аймгийн Дархан карьераас гэрээгээр татан авч байна.	
3		Шороон замаар зорчих ачааны автомашинуудын хоорондын зайг 20 метрээс багагүй байхаар тогтоож,	Шороон замаар зорчих тээврийн хэрэгслүүдийн хурдыг 30-40 км/цаг-аар хязгаарлах буюу энэ хурднаас хэтрүүлэхгүй байх хоорондын зай барих	• Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS

		өмнөх машины үүсгэсэн тоос сарниж үзэгдэх орчин сайжрах боломжийг олгох, замын ачаалалд хяналт тавих	чиглэлээр зааварчилга өгч ажиллаж байна.	4585:2016 • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он
4		Шороон зам дагууд замын анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, санамж бүхий самбар байршуулж, барилгын ажилчид болон материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслүүдийг зөвхөн нэг замаар зорчих нөхцөлийг бүрдүүлэх, шинээр олон салаа шороон зам үүсгэхгүй байх арга хэмжээ авах	Орон нутгын хуучин ашиглаж байсан замыг ашиглаж байна. Барилгын талбай хүртэл замын маршрутын зураглал гаргаж жолооч нарт үүрэг чиглэл өгч ажиллаа.	• Машин механизмуудын ажиллагааны дүрэм • Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
5		Салхинд хийсч тоос үүсгэхгүйц материал тээвэрлэхдээ тээврийн хэрэгслийн ачааны хэсгийг битүүмжлэн хучих арга хэмжээ авах	Шороо болон хайрга тээвэрлэж буй тээврийн хэрэгсэлийг битүү хучлагатай явуулж, тоосожилт үүсэхээс сэргийлж ажилласан.	
6	Хүнд даацын машин механизмын дутуу шаталтат хөдөлгүүрээс бохирдуулагч ялгарч агаар бохирдуулах	Барилга, газар шорооны ажлын үед ашиглах хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжинд сайн чанарын түлш ашиглаж агаарт ялгарах хийн төлөвт бохирдуулагчийг багасгах	Машин механизмд зохих стандартын шатах тослох материалаар хангаж, Сумын Петровис ХХК-ны салбартай хамтран ажилласан.	-

7	Услалтын системийн барилга газар шорооны ажлын үед ашиглах элс, хайрга, цемент зэрэг материалуудын овоолгоос салхины үйлчиллээр тоос босох	Полиэтилен болон давуун хучлагаар барилгын материалаа (элс, хайрга, цемент г.м) хучих, Задгай талбайд овоолох барилгын материалыг газрын гадаргаар тархахаас сэргийлж хаалт, хашилт хийх	Зам талбайд ашиглах элс хайргаа, цементээ салхи, шуурганаас хамгаалах боломжит аргаа хэрэглэж байгаа ба мөн хучилт хийж байна.	-
8		Нийт машин механизмуудыг үзлэг оношилгоонд хамруулж, шаардлагатай бол хөдөлгүүрийг шинэчилж сайжруулах, хорт утаа ихээр ялгаруулж буй машин техникийг барилгын ажилд ашиглахгүй байх, шаардлагатай үед хаягдал утааг шүүх шүүлтүүр, катализатор хэрэглэх	Бүх төрлийн машин механизм, техникүүдийг 2022 оны үзлэг оношилгоонд хамруулан ажилласан.	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016-
9	Бензин, шатах тослох материалын хадгалалтын горим алдагдсанаас агаар бохирдуулах	Бензин, шатах тослох материалыг асгарч, ууршихааргүй байдлаар сайтар таглаж битүүмжлэн нарны шууд тусгал, галын эх үүсвэрээс тусгаарлан хадгалах, шатах тослох материалаар агаар бохирдох, шаталт үүсгэж агаарт хорт хий ялгаруулахаас сэргийлэх	Бензин, тосолгооны материалуудаа тусгай газарт /нар, салхинаас хамгаалсан/ байрлуулан ашиглаж арга хэмжээ авч байна	“Бензин хөдөлгүүртэй автомашин- утааны найрлага дах хорт бодисын ЗДХ ба хэмжих арга” MNS 5013:2009
10	Шаардлагагүй газарт газар хөндөх, ухаш овоолго үүсгэж газрын	Барилгажих талбайн гадна талаар хамгаалалтын зурвас байгуулж, хамгаалалтын	Ажил хийгдэж буй талбайд хамгаалалтын ногоон тор татаж тэмдэг тэмдэглэгээ хийсэн	<ul style="list-style-type: none"> • Барилгын тухай хууль, 2016 он • Хөрс хамгаалах,

	гадарга, хөрсөн бүрхэвчийг талхлан доройтуулах	зурвас доторх газарт төлөвлөлт, зураг төслийн дагуу үйл ажиллагаа явуулах, тухайн орчимд тэмдэг тэмдэглэгээ, анхааруулах самбар байршуулах		цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012 он
11	Далан суваг байгуулах үйл ажиллагааны явцад хөрсөн бүрхэвч хүчтэй эвдрэх;	Услалтын систем байгуулах газар шорооны ажлын үед өнгөн хөрс-ялзмаг бүхий хөрсийг тусад нь хуулан авч тусгай газарт чанарыг алдагдуулахгүйгээр хадгалж ажил дууссаны дараа эвдрэлд орсон орчмын газруудад нөхөн сэргээлт хийх -Ажиллагсдын суурин байгуулахад өртөж эвдэрсэн хөрсийг засаж тэгшлэх, нөхөн сэргээх.	Өнгөн хөрсөө хуулан хадгалах талаар ажилчиддаа анхааруулан ажиллаж байна. Ажил дууссаны дараа нөхөн сэргээлтэд ашиглах талаар зааварчилгаа өгсөн.	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012 он. Байгаль орчин. Газар шорооны ажлын үе хөрс хуулалт, хадгалалт MNS 5916 : 2008
12	Хүнд даацын машин механизм болон автомашин забараагүй явснаас газрын гадарга хөрс хүчтэй эвдрэлд орох	Эвдрэл, доройтолд ороогүй болон газруудад машин, техник орохыг хязгаарлах, олон салаа зам гаргахгүй байх, тэмдэглээ хийх	Тодорхой замын маршрут гаргасан. Энэ маршрутаар явах, олон салаа зам гаргах маршрутаас өөр замаар явах асуудлыг хориглосон байгаа.	

13	Гадаргын усны урсац, горим өөрчлөгдөх	Барилгын ажлын үед голын байгалийн үндсэн голдирол, урсацыг өөрчлөх үйл ажиллагаа явуулахгүй байх	Голын урсац, голдирол өөрчлөлт хийхгүй байх талаар анхаарч ажиллаж байна.	<ul style="list-style-type: none"> Усны тухай хууль, 2012 он Монгол Улсын Барилгын норм ба дүрэм, “БНБД 33-09-10 Усжуулалтын систем, түүний байгууламж” 2010 он
14		Барилгын ажлын үед усан сан бүхийн газрын онцгой хамгаалалтын бүсэд (голын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд) хамаарах газраас элс, хайрга чулуу авч ашиглахгүй байх	<p>Үүнийг мөрдөж ажиллаж байгаа.</p> <p>Барилгын ажилд хэрэглэгдэж буй хайрга, дайргыг Дархан-Уул аймгын Дархан карьераас гэрээгээр татан авч байна.</p>	
15		<p>Голын усанд машин угаах, голын ойр орчимд бие засах, хог</p> <p>хаягдал ил задгай хаяхгүй байх талаар барилгын ажилчдад хатуу анхааруулах ба үүнд талбайн инженер хатуу хяналт тавьж ажиллах</p>	Үүнийг бүх ажилчиддаа анхааруулан, мөрдөж ажиллаж, сумын байгаль орчны байцаагчтай хамтран хяналт тавьж ажилласан.	<ul style="list-style-type: none"> Усны тухай хууль, 2012. Усны чанар. Гүний усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх агууламж, MNS 6148:2010
16	Усан орчныг бохирдуулах	Бүх машин механизм, ажилчдын голын суваг руу орох, гарах гарцыг хатуу зааглаж тогтооно. Энэ нь суваг болон амьдрах орчны ойролцоох хэсгүүдэд үзүүлэх нөлөөллийг багасгана.	Гарц тэмдэглээ хийсэн	

17	Барилга байгууламжийн үйл ажиллагааны нөлөөгөөр орчмын ургамалан бүрхүүл доройтох, устах	Барилгын материал, машин механизмуудыг ургамлан нөмрөг бага буюу аль холбох халцгай газарт байрлуулах, байгалийн ургамалтай газарт барилгын материал буулгах, машин механизмын зогсоол болгон ашиглахгүй байх	Аль болох ургамал багатай газар материалуудаа буулгах, ургамлын нөмрөгийг хамгаалах талаар ажилчиддаа сануулж байгаа. Барилгын материал болон бетон үйлдвэрлэл үйлдвэрээ сумын төвийндэрэгдэх 2-р кемп дээр төвлөрүүлээд байна.	<ul style="list-style-type: none"> • Байгалийн ургамлын тухай хууль, 1995 он • Ургамал хамгааллын тухай хууль, 2007 он • Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 08 дугаар сарын 25 – ны өдрийн 153 дугаар тогтоол, Ховор ургамлын жагсаалт
18		Барилгажих талбайд ховор, нэн ховор статустай, эмийн ач холбогдол бүхий хамгаалах шаардлагатай ургамал байвал түүний нөөц, чанарт сөрөг нөлөөлөл учруулахгүй байх	Энэ үйл ажиллагаа явуулж байгаа газар нэн ховор болон ховор ургамал байхгүй	-
19	Гадаргын усны ууршилт ихсэх, хөрс, ургамал доройтох	Услалтын системийн ойролцоох мод, сөөгийг сэргээн усалгаа арчилгааг тогтмол хийж байна	Орчмын мөд, сөөгийн хамгаалах, гэмтээхгүй байх талаар ажилчиддаа санамж өгч ажиллаж байна.	-
20	Мод, бут, сөөгийг гэмтээх ургалтыг зогсоох,	Мод, бут, сөөг тарих зүлэг ногооруулалт хийх чиглэлийн сургалтын гарын авлага боловсруулах , орон нутгийн ногоочид, малчдад сургалт явуулах	Мод бут тарих, гарыг нөхөн сэргээж чиглэлээр малчдад зориулсан гарын авлага боловсруулан тараах чиглэлээр материал бэлтгэж байна.	-
21	Зэрлэг амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөнд саад учруулах	Хэрэв барилгын ажлын явцад зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнтэй таарвал үргээлгүй зам тавьж өгөн өнгөрөөж байх	Зэрлэг амьтдыг хамгаалах, тэдгээрийг үргээхгүй тааваар нь байлгах талаар ажилчиддаа ажил эхлэхээс нь өмнө сануулж ажиллаж байна.	<ul style="list-style-type: none"> • Амьтны тухай хууль, 2012 он • Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 01 дүгээр сарын 11- ний өдрийн 7 дугаар тогтоол, Ховор амьтны
22	Нүүдлийн шувуудыг үргээх, амьдарлын хэв	Нүүдлийн шувууд дайран өнгөрдөг хугацаанд шувуудыг үргээдэг хүчин	Шувуудад сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх, үргээх, үүр зассан	

	маягийг нь өөрчлөх, тааламжгүй нөхцөлийг бүрдүүлэх	зүйлүүдэд хяналт тавьж, ажилчдад мэдээлэл өгч шувуудыг аль болохоор үргээж цочоохгүй байх	бол түүнийг хөндөхгүй байх талаар анхаарулсан.	жагсаалт
23	Хууль бус ан агнуурын үйл ажиллагаа явагдах	Барилгын ажилчдад хууль бус ан агнуур хийхгүй байх, худалдаалахгүй байх талаар анхааруулга өгч, хяналт тавьж ажиллах	Ажилчдад ажил эхлэхээс өмнө аливаа хууль бус антай холбогдолтой үйл ажиллагаа явуулсан бол гэмт хэрэг гэж үзэх талаар анхааруулга санамж сумын цагдаагийн хэсэгтэй хамтран сургалт өгсөн.	
24	Далангийн хаалтыг хаалттай байлгаснаас загас дамжин өнгөрөх боломжгүй болох	Суваг шуудуу, толгойн барилгын хаалт зэргийг загас өнгөрүүлэх боломжтой байхаар төлөвлөн байгуулах	Үүнийг анхаарч ажиллаж байна.	Монгол Улсын барилгын норм ба дүрэм, “БНБД 33-09-10 Усжуулалтын систем, түүний байгууламж” 2010 он
25	Урьдчилан хяналт шалгалт хийгээгүйн улмаас амьтдад хор хохирол учруулах	Барилгажих талбай болон түүний ойр орчимд ямар нэг амьтны төрөл зүйл байгаа эсэх, амьтны үүр, үржлийн дэвсгэр нутаг байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор талбай дээр шалгалт хийх.	Анх ажилд гарахаас өмнөх үеэс эхлэн үүнийг анхаарах талаар ажилчиддаа даалгавар өгч, хэрэв бэртэж гэмтсэн амьтантай таарах нөхцөлд байгаль хамгаалагчдад мэдэгдэх нь зүйтэй гэсэн чиглэл өгч ажиллаж байна.	<ul style="list-style-type: none"> • БОНБНҮ- ний тайлангийн 4-р бүлгийн амьтны аймгийн зөвлөмжийн хэсэгт тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх Амьтны тухай хууль, • 2012 он

26	Ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл бий болгох	Дуу чимээ ихтэй нөхцөлд ажиллаж буй ажилчдыг дуу чимээг багасгаж сонсголын эрхтэн системийг хамгаалах хэрэгслээр хангаж хэрэглүүлж хэвшүүлэх	Дуу чимээтэй ажиллаж байгаа хүмүүст чихний сонсгол хамгаалах хэрэгслэл тавьж өгсөн	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага MNS 6768:2019
----	---	--	--	---

27		Барилгын ажлын үед аль болох дуу чимээ багатай машин механизмыг сонгож ашиглах, дуу чимээ ихээр гаргадаг машин, механизмыг дуу намсгагчаар тоноглож чимээ шуугианыг аль болгох бага гаргах, сул зогсох, ажиллагаагүй үедээ машин механизмаа тогтмол унтрааж хэвшүүлэх.	Ажилчдад энэ талаарх хангалттай мэдээлэл өгсөн ба тэд үүнийг мөрдөн ажиллаж байгаа	<ul style="list-style-type: none"> • Барилгын тухай хууль, 2016 он • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь дуу шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага MNS 6768 : 2019
28		Барилгын материал тээвэрлэж буй машин сургууль, эмнэлэг, суурьшлын бүс зэрэг чимээнд мэдрэг газруудаар дайрч өнгөрөх, эдгээр газрын ойр орчимд явахдаа хурдаа хасах, дуут дохио ашиглахгүй байх	Тээврийн үйл ажиллагаа эрхлэх жолооч, ажилчдад тээвэр хийх зам дагуух хүн амын тайван байдлыг алдагдуулахгүй байх шаарлагатай бус бол дохиолол өгөхгүй байх чиглэлийг баримтлан ажиллаж байна.	<ul style="list-style-type: none"> • Эрүүл ахуйн тухай хууль. 2016 он
29	Орон нутгийн иргэдэд тодорхой мэдээлэл өгөөгүйн улмаас үл ойлголцол үүсэх	Барилгын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэх хугацаа, хийгдэх ажлуудын талаар иргэдэд мэдээлэл өгөхүйц мэдээллийн самбарыг барилгын талбайн орчимд байршуулах	Мэдээллийн самбар байрлуулсан.	<p>“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль. 2012 он</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль орчныг хамгаалах тухай • хууль, • Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль • Хөдөлмөрийн аюулгүй
30		Барилгын ажлын явцад орон нутгийн иргэдээс ирсэн аливаа санал гомдлыг хүлээн авч богино хугацаанд шийдвэрлэх,	Өнөөгийн байдлаар гомдол, саналгаргасан зүйл байхгүй байна.	

		шаардлагатай тохиолдолд нэгдсэн журмаар мэдээлэл өгөх		байдал, эрүүл мэнд, Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага. MNS 4990 : 2015
31	Хүрээлэн буй орчинд тоос ихээр үүссэнээс харшилтай болох гэх мэтээр хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй.	Барилгын ажлыг аль болох орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байхаар төлөвлөж, тоосжилт, дуу чимээг багасгах, бууруулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх	Орон нутгийн иргэдэд тоосжилт, дуучимээний зэрэг амьдрал ахуйд нь сөрөг нөлөөлөл учруулах хүндрэлтэй байдал учруулахгүй байгаа.	
32	ХАБЭА-н дүрэм зөрчигдөх, осол аваар гарах	Барилгын ажилчдад ажил эхлэхээс өмнө ХАБЭА-н зааварчилгаа өгч, , хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжөөр бүрэн хангах, хэрэглүүлж хэвшүүлэх	Бүх ажилчдад ажлын байранд мөрдөх аюулгүй ажиллагааны заавар танилцуулан, ажилд гаргаж байгаа 5,9 сард нэгдсэн сургалтад хамруулж, хувцас хэрэгсэл, Ээгслэлээр хангасан.	Хөдөлмөрийн аюулгүй байдал,
33		Машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байх, эвдэрч доголдсон тоног төхөөрөмжийн ашиглалтыг нэн даруй зогсоох		эрүүл ахуйн тухай хууль, 2008 он Тээврийн хэрэгсэлд тавих техникийн шаардлага. MNS 4598:2011.
34	Анхны тусламж үзүүлэх эм тариа, багаж хэрэгсэл байхгүйн улмаас ослын нөхцөлийг хүндрүүлэх	Ажилчдад аливаа болзошгүй аваар ослын үед анхны тусламж үзүүлэх сургалт зааварчилгааг өгч, анхны тусламжийн эм тариа, багаж хэрэгслийг бэлэн байлгах	Машин механизм дээр ажилдаг ажилчдад анхан шатны тусламж үзүүлэх талаар сургалт явуулсан	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль. 2008 он
35		Хамгийн ойр байршилтай эмнэлэг, түүнд хүрэх хамгийн дөт замыг тодорхойлох	Сумын эмнэлэгтэй ярилцан хамтран ажиллахаар тохиролцож холбоо барих утасны дугаарыг кэмп болон ажлын байранд ил тавьсан.	
36		Хамгийн ойр байгаа эмнэлэг хүрэх зам, холбоо барих мэдээллийг		

		агуулсан зургийг ажлын талбай бүрт байршуулах		
37	Гал унтраах багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангаагүйн улмаас ослын нөхцөлийг хүндрүүлэх	Галын аюулын үед хэрэглэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг байнга цэнэглэж гэнэтийн болзошгүй аваар ослын үед хэрэглэхэд бэлэн байлгах	Галын аюулын үед яаралтай тусламжийн багаж, хэрэгслэл элс, галын хор зэргийг бэлтгэж тавьсан	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага MNS 4244: 1994 • Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS5566:2005

2. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ДД	Төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ		Баримтлах хууль эрх зүйн баримт бичиг
1	Хог хаягдлыг ил задгай хаях замаар орчныг бохирдуулах	Барилгын талбайн орчимд ил задгай хог хаяхгүй байхыг нийт ажилчдад сайтар анхааруулах ба орчны хог хаягдлыг тогтмол түүж цэвэрлэх	Хог хаягдал хаяхгүй байх орчныг хогоор бохирдуулахгүй байх талаар бүх ажилчид анхаарч ажиллаж, Байнгын харуул, хяналт тавьж Ажилласан.	<ul style="list-style-type: none"> • Хог хаягдлын тухай хууль, 2017 он • Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны тушаал А/349 2, “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл” • Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 2А/443 тушаал, Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага
2		Барилгын ажил дуусахад талбай дээр ямар ч хог хаягдал үлдээхгүй цэвэрлэж явах	Үүнийг тогтмол хийж байсан.	
3	Барилгын ажлыг төлөвлөлт муутай хийснээс үүсэх хаягдлын хэмжээ нэмэгдэнэ.	Ажлын хэмжээнээс хамаарч ашиглах материалын орц найрлага, хэмжээг зөв тохируулан аль болох хаягдал үүсгэхгүй байх, хаягдлыг хамгийн бага байхаар төлөвлөж ажиллах	Үүнийг мөрдөн ажиллаж байна.	
4	Барилгын материалын болон ахуйн хаягдлаар орчныг бохирдуулах	Барилгын материалын хаягдлыг богино хугацаанд төслийн талбайгаас зайлуулах, хог хаягдлыг нэг цэгт төвлөрүүлэх, үүссэн хаягдлыг хийсч тархахааргүй битүүмжлэл сайтай цэгт түр хадгалах арга хэмжээ авах	Хог хаях цэг байгуулсан ШТМ-г тухай бүрд нь техник дээр нь шалгаж байгаль орчинд нөлөө үүсгэхгүйгээр ажиллаж байна	<ul style="list-style-type: none"> • Хог хаягдлын тухай хууль, 2017 он • Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344: 2011
5	Ахуйн шингэн хог хаягдлаар газрын	Ахуйн хатуу, шингэн хаягдлыг барилгын талбайн орчимд ил	Ажилчдын кэмпнээс гарах хатуу, шингэн хог хаягдлыг	“Нүхэн жорлон, угаадасны нүх” Техникийн шаардлага MNS

	хөрсийг бохирдуулах	задгай асгахгүй байх, ажилчдын бие засах газрыг зориулалтынбио ариун цэврийн байгууламж байгуулах	тусгай зориулалтын саванд цуглаалах бие засах газрыг зохих шаардлагын түвшинд байгуулан хэрэглэж байна.	5924:2015
6	Бүх төрлийн шатах, тослох материалаар ажилладаг машин механизм, тээврийн хэрэгслүүдийн ашиглалтын үед шатах тослох материал асгарч хөрс бохирдуулах	Шатах тослох материалаар бохирдсон хөрсийг нэн даруй хусаж аван хөрсний гүн рүү нэвчихээс сэргийлэх	Шатах тослох материалыг газрын хөрсөнд асгахаас болгоомжлох,хэрэв санамсахгүй, болгоомжгүйгээс асгарсан тохиолдолд нэн даруй цэвэрлэх чиглэл өгч байгаа	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 : 2019-
7		Шатах тослох материал их хэмжээгээр асгарсан бол элс, даавуу зэрэг шингээгч материалд шингээн авч битүү саванд хийх, асгарсан хэсгийн хөрсийг хуулж авах зааварчилга өгсөн.		
8	Хогийн цэгийг зохих шаардлагад нийцүүлэн байгуулаагүйгээс хатуу хаягдлаар бохирдуулах, хөрс, гадаргын болон газрын доорх ус нянгаар бохирдож болзошгүй.	Дахин боловсруулах боломжтой хаягдлыг нягтаршуулах зориулалт бүхий “хаягдал пресслэгч машин” худалдан авч ангилан ялгасан хаягдлуудыг нягтаршуулан тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх		Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344: 2011 • Хог хаягдлын тухай хууль, 2017 он Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 А/443 тушаал, Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага-
9		Пресслэгч машинаар нягтаршуулсан хаягдлыг Улаанбаатар хотод байрлах дахин боловсруулах үйлдвэрүүд	БНХАУ-аас авахаар захилга өгч 2023 онд авахаар гэрээ хийх шатандаа явагдаж байна.	
10		Дахин боловсруулах боломжгүй ахуйн хаягдлыг 7 хоногт нэг удаа сумын хог хаягдлын төвлөрсөн	Хог хаягдлыг сумын хог хаягдлын цэгт ачилт хийн зөөвөрлөх асуудлыг холбогдох	

		цэгт зөөвөрлөх	улсуудтай гэрээ хийж хогоо хаягдалаа хаясан.	
11		Хаягдлын цэгийн талбайг сонгохдоо салхины зонхилох чиглэлийн доор уст цэгээс 300 м-ээс доошгүй зайд, байр сууц, хоолны газраас 100 метрээс багагүй зайд, бие засах газраас тусад нь нэг цэгт байрлуулах ба хатуу хог хаягдлын цэгийг ялаа, шавж үржихээс сэргийлэн тогтмол ариутгаж байх	Үүнд заасны дагуу бие засах газар болон хог хаягдлын цэгээ байршуулсан	<ul style="list-style-type: none"> • Хог хаягдлын тухай хууль, 2017 он
12	Аюултай хаягдлыг ил задгай хадгалсанаас үүдэлтэй хөрс, ус хүнд металлаар бохирдох, агаарт ууршилт явагдах, мал, амьтан хордж эрсдэлд орж болзошгүй	Засвар үйлчилгээний үед гарах бензин, тос, шатах тослох материалын үлдэгдэл, тэдгээрийн сав багалаа боодол зэрэг аюултай хаягдлуудыг түр хадгалах тусгай зориулалтын агуулах байгуулах ба агуулах нь бохирдуулагч бодис хөрсөнд нэвчихээс сэргийлсэн гадаргуутай, нарны шууд тусгал, галын эх үүсвэрээс тусгаарлагдсан битүүмжэл сайтай байна. Хуримтлагдсан аюултай хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх ба энгийн хаягдалтай хамт хаяхыг хориглоно.	Хог хаягдлын цэг байгуулсан, аюултай хог хаягдлын ангиллын хог хаягдал одоохондоо гараагүй бөгөөд цаашид гарсан нөхцөлд эдгээрийг зөөвөрлөн хаана хүргэх асуудлаар холбогдох хүмүүстэй ярилцсан.	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчныг хамгаалах тухай хууль • Хог хаягдлын тухай хууль. 2012

3. ОСОЛ, ГЭМТЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТ

ДД	Төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ		Баримтлах хууль эрх зүйн баримт бичиг
1	Машин механизм, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал алдагдсанаас осол аваар гарах эрсдэлтэй.	Барилга, газар шорооны ажилд хэрэглэх машин механизм, техник тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг бүрэн хангасан байх	Машин мехназмын үзлэгт 2022 онд хамруулсан баг оношилгоо хийлгэсэн 7 хоног бүр тосолгоо, үйлчилгээг хийж ажилласан.	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 4968 : 2000 • Тээврийн хэрэгсэлд тавих техникийн шаардлага MNS 4598:2011
2		Хэрэв ажлын талбай дээр машин механизм, тээврийн хэрэгсэл эвдэрсэн бол засварын газарт шаардлагатай бүх засвар үйлчилгээг хийсний дараа үйл ажиллагаа явуулах	Машин механизмын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж, техникийн доголдол гарсан тохиолдолд засвар үйлчилгээг шаардлагын дагуу хийж талбайд гаргаж ажилласан.	
3	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангаагүй эсвэл хэрэглээгүй, ХАБЭА-н дүрэм зөрчигдсөн үед болзошгүй осол аварт өртөх	Барилгын талбай дээр ажиллах бүх ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж, хэрэглүүлж хэвшүүлэх	Талбай дээр ажиллагсдад каск, хантааз, гутал, бээлий, нүдний шил зэргээр хангаж ажилласан.	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн хамгаалах хэрэгслэл Ерөнхий шаардлага , ангилал MNS 4931 : 2000 • Аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө MNS4643:1998 • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
4		Бүх ажилчдад ХАБЭА-н зааварчилгаа өгч гарын үсэг зуруулах, ХАБЭА-н зааварчилгаанд хамрагдаагүй ажилчдыг барилгын талбай дээр ажиллахыг хориглох, үүнд ХАБЭА-н ажилтан байнга хяналт тавьж хариуцлагатай ажиллах	Бүх ажилчдад ХАБЭА зааварчилгаа өгч, сургалтад хамруулсан.	

5	Машин механизмын ашиглалтын ХАБЭА-н дүрэм зөрчигдөж осол аваарт өртөх	Барилгын материал ачиж буулгах, өргөх зэрэг эрсдэлтэй алхмуудыг ХАБЭА-н инженерийн хараа хяналтанд гүйцэтгэх ба аюулгүй байдлын ажилтан шаардлагатай тохиолдолд зааварчилгаа өгөх	Ажлын байр эрсдэлтэй буюу эрсдэлтэй үйлажиллагааны үед инженерийн хараа хяналтанд гүйцэтгэх чиглэлийг баримтлан ажиллаж байсан.	<ul style="list-style-type: none"> • Тээврийн хэрэгсэлд тавих техникийн шаардлага MNS 4598:2011. • Барилгын ажилд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах нийтлэг журам • Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Ачих буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5079:2001 • Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Өргөх, зөөх ачааны массын дээд хэмжээ MNS4970:2000
6	Ослын нөхцөл хүндрэх	Ажилчдад анхан шатны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх, анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг байнга бэлэн байлгах	Анхан шатны тусламжийн материалуудыг ажлын байранд бэлэн байлгах арга хэмжээ авч ажилласан.	<ul style="list-style-type: none"> • “Гамшгаас хамгаалах тухай” хууль, 2003 он; • “Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль, 2012 он; • “Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” MNS 4244-94
7		Барилга, газар шорооны ажил явагдах талбайн орчимд анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, санамж байрлуулах, хязгаарлалтын бүс тогтоох	Анхааруулга тэмдэглэгээ, санамжийг байрлуулан ажиллаж байсан.	

8	Болзошгүй аюул ослын улмаас гал гарах	Галын аюулгүй байдлыг хангаж, гал унтраах анхан шатны болон суурин тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг байршуулах, галын хор цэнэгтэй эсэхийг байнга шалгаж, цэнэг нь дууссан бол цэнэглүүлж байх	Гал унтраах хор, элс хүрз зэрэг зүйлийг бэлэн байлгаж байсан.	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага • MNS 5150 : 2002 • Аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө MNS 4643 : 1998
9	Байгаль, цаг аюултай үзэгдлийн улмаас осол гарах уурын гэнэтийн	Цаг агаарын аюулт үзэгдэл зарласан өдрүүдэд бүх ажилчдад дуулган, сонор сэрэмжтэй ажиллахыг сануулах, аян замд гарахгүй байх, төслийн үйл ажиллагаанд хязгаарлалт хийх, онцгой тохиолдолд ажиллуулахгүй байх арга хэмжээ авах л болж болзошгүй сэрэмжлүүлэг	Цаг агаарын мэдээлэлийг өдөр бүр,7 хоног, сараар Зохиох анхааруулгыг өгч ажиллаж байсан.	
10	Байгаль, цаг уурын гэнэтийн аюултай үзэгдлийн улмаас осол гарах	Шороон шуургатай өдрүүдэд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдад хязгаарлалт хийх, сонор сэрэмжлүүлгийг өндөржүүлэн ажиллах	Үүнийг анхаарч ажиллаж байсан.	

4. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТ

ДД	Төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ		Баримтлах хууль эрх зүйн баримт бичиг
1	Биологийн нөхөн сэргээлт хийж эвдэрсэн газрыг байгалийн унаган төрхөнд нь эргүүлэн оруулах	Тэгшилж зассан газарт орон нутгийн унаган олон наст ургамлын үр тарих, мод, сөөг суулгах зэргээр нөхөн сэргээлт хийх	Нөхөн сэргээлтийн ажил одоохондоо хийгдээгүй байна. Энэ төслийн ажил 4 сард эхэлсэн бөгөөд ажлын бэлтгэл, машин механизм болон	<ul style="list-style-type: none"> Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт , хадгалалт MNS 5916 : 2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS 5914:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS 5918:2008 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2011
2	Биологийн нөхөн сэргээлт хийх нөхцөлийг бүрдүүлэх	Барилга, газар шорооны ажил дууссаны дараа эвдрэлд орсон талбайг хэлбэршүүлэх, тэгшлэх, үржил шимт хөрсөөр хучих, шаардлагатай тохиолдолд хөрс сайжруулалт хийх зэргээр ургамалжуулах урьдач нөхцөлийг бүрдүүлэх	шаардагдах материалууд мөн түгээмэл тархацтай ордуудаас барилгын материал зэргийг татах ажлуудыг хийж, суваг, шуудууны ажил 3.2 км явж байна.Мод сөөг тарих болон нөхөн сэргээлт хийх ажлыг Сэлэнгэ аймгийн мэргэжилийн Компаниудаар хийлгэхээр судалгааны ажил хийж байна.	<ul style="list-style-type: none"> Мод, сөөгний үрийг тарихад бэлтгэх. Ерөнхий шаардлага MNS 6253-1 : 2011 Мод, сөөгний үр тарих. Ерөнхий шаардлага MNS 6253-2 : 2011 Мод, сөөгний үр тарьсны дараа арчлах. Ерөнхий шаардлага MNS 6253-3 : 2011 Мод, сөөгний суулгац арчлах MNS 6258-2 : 2011 Мод үржүүлгийн газарбордоо хэрэглэх MNS 6252 : 2011
3		Услалтын системийн талбайг баруун, хойд хэсэгт 14700 ш мод сөөг тарьж 5.9 га талбайд ойн зурвас байгуулах		

5. Химийн хорт ба аюултай бодисын эрсдлээс сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө

ДД	Төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ		Баримтлах хууль эрх зүйн баримт бичиг
1	Химийн бодисуудын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтын горим алдагдсанаас химийн бодисын нөлөөлөлд өртөж хүний эрүүл мэнд амь нас хохирох, байгаль орчин химийн бодисоор бохирдох	Ургамал хамгааллын бодисуудыг стандартын шаардлага хангасан 2 тасалгаа бүхий агуулах байгуулж хадгалах	ХХААЯам болон төслийн нэгжээс нэгдсэн зураг төслөөр бариулах зураг төсөл боловсруулж өгөхөөр болсон ч энэ жил зураг төсөл хийгдээгүй улмаас хойшилогдсон.	<ul style="list-style-type: none"> • Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 2016 он • Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 458 : 2014 • Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458 : 2014
2		Хөдөө аж ахуйн химийн бодистой зохистой харьцах хэрэглээний аюулгүй ажиллагаагаар ногоочидод зориулсан гарын авлага боловсруулж гаргах	Агуулах барилга баригдсны дараа тухайн орчинд зохицсон таниулах материалыг бэлдэхээр төлөвлөж байна.	<ul style="list-style-type: none"> • Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 2016 он • Бодисуудын хор аюулын лавлах мэдээлэл (MSDS)

ХИМИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ, ДҮГНЭЛТ

Ивэн голын усалтын системийн барилга байгууламж барих үеийн орчны бохирдын байдалыг хянах зорилгоор агаар, ус, хөрснөөс дээж авч, Байгаль орчны шинжилгээний лабораториор шинжлүүлж, дүнг дор үзүүллээ.

Агаарын шинжилгээ:

Хэмжилт хийсэн газар	Элементүүд мг/м ³				
	Азотын давхар исэл (NO ₂)	Хүхрийн ангидрид (SO ₂)	Тоос (нийт)		
Усалтын системийн ажил хийгдэж байгаа газарт	0.016	0.010	Дундаж	Хамгийн бага	Хамгийн их
			0.057	0.007	0.417
MNS 4585:2016 Стандарт дахь хүлцэх агууламж	0.200	0.450	0.500		

Дүгнэлт: Агаарын бохирдлын үндсэн үзүүлэлтүүд болох хүхрийн ангидрид, азотын давхар исэл болон тоосны хэмжээ нь зохих стандартын түвшинээс хэтрээгүй байна.

Усны шинжилгээ:

Шинжилгээ хийсэн элементүүд	Үр дүн	MNS 4586:1998
	Голын дунд хэсэг	
Ph орчин	7.80	6.5-8.5
Өнгө	30.53	20.0
Кальци	32.6	100.0
Магни	19.8	30.0
Аммони азот	0.21	0.5
Төмөр /нийт/	0.00	0.3
Хлор	2.1	350.0
Сульфат	47.0	100.0
Нитрит	0.007	0.02

Нитрат	0.37	9.0
Гидрокарбонат	137.3	
Хатуулаг	3.25	0.1
Перманганатын исэлдэх чанар	4.2	
Фтор	0.67	0.7-1.5
Эрдэсжилт	239.6	
Na+K	0.81	
Фосфор	0.022	0.1
ЕС мг/см	244.0	
Булингар	22.0	1.5
Цахиур	1.22	
Хром 6+	илрээгүй	0.01

Дүгнэлт: Уг ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд хатуувтар ус байна. Шинжилсэн үндсэн үзүүлэлтүүд нь “Усан орчны чанарын үзүүлэлт Ерөнхий шаардлага. MNS 4586:1998” –ын шаардлага хангаж байна гэсэн дүгнэлт гарсан байна.

Хөрсний шинжилгээ:

Услалтын систем хийгдэж буй орчинд	Тодорхойлсон элементүүд мг/кг							
	Ph	ЕС	Фосфор	Сульфат	Чийг %	Нитрат	Аммони азот	Ялзмаг
	6.72	37.1	12.16	124.3	1.10	10.9	66.48	1.0
Стандарт MNS 3297:2019	6-9			160.0	-	130.0	-	-

Уг хөрсөнд тодорхойлсон үзүүлэлтээр (Ph)-нь шүлтлэгээс саармаг орчинтой гарсан байна. Энэ нь ургамал ургахад тохиромжтой хөрс болно.

Ялзмаг нь ургамал болон амьтны гаралтай үлдэгдэл материалын задралаас хөрсөнд үүсдэг бараан өнгөтэй, эрдэс органикийн нийлмэл бодис юм. Ялзмаг нь өөртөө маш олон төрлийн шим тэжээлийн бодисыг (ялангуяа азотыг) агуулж байдаг учраас хөрсний үржил шимийн хамгийн чухал үзүүлэлт болдог. Харин энэ хөрсөнд ялзмагийн хэмжээ бага гарсан байна.


Хөрсний цахилгаан дамжуулах чанар (ЕС) буюу хялбар уусах давсжилт. ЕС буюу хөрсний цахилгаан дамжуулах чанар нь хөрсөн дэх усанд хялбар уусах давсны хэмжээг (хөрсний давсжилт) тодорхойлдог үзүүлэлт юм. Энэ нь хөрсний чанарын чухал үзүүлэлт болдог бөгөөд ЕС нь ургамлын ургац, ургамалд тохиромжтой байдал, ургамлын тэжээллэг чанар, хөрсний бичил биетний үйл ажиллагаанд нөлөөлдөг. Энэ хөрсний цахилгаан дамжуулах чанар нь их давсархаг байдалтай байна.

Хөрсний хөдөлгөөнт фосфор, азот нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь л дутагдахад ургамал ургах боломжгүй болдог. Азот (N) нь ургамлын өсөлтөд чухал үүрэгтэй бөгөөд фотосинтезийн үйл явцад амин чухал нөлөөтэй юм. Энэ хөрсний дээжид фосфор, калийн агууламж нь сайн байна.

Агаар болон хөрс, усны шинжлэлгээний хариу

УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,
2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983



БАЙГАЛЬ ОРЧНЫ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2022 /А32

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас
Дээжийн тодорхойлолт
Дээж авсан хүний нэр, албан тушаал
Дээжийн тоо, төрөл
Хүлээн авсан огноо
Сорилтын арга, аргачлал

"Бридж констракшин" ХХК
Сант сум
БОШЛ-ийн ерөнхий инженер М.Аягүл
1, Агаарын дээж
2022 - 10 - 28
MNS0017-2-5-12:2021
MNS0017-2-5-11:2021, MNS4048-88

Дээжийн тодорхойлсон үзүүлэлт
Шинжилгээ хийж дууссан огноо

хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос
2022 - 10 - 31

АГААРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Хэмжилт хийсэн цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд мг/м3				
		Азотын давхар исэл (NO2)	Хүхэрлэг хий (SO2)	Тоос (нийт)		
				Дундаж	Хамгийн бага	Хамгийн их
1	Усалтын системийн ажил хийгдэж буй газрын орчим	0.016	0.010	0.057	0.007	0.417
MNS4585:2016 стандарт дахь хүлцэх агууламж		0.200	0.450	0.500		

Дүгнэлт:

Сант сумын Ивэн багийн нутагт "Бридж констракшин" ХХК-ны усалтын систем хийгдэж буй орчмын агаар MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас даваагүй байна.


Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер..... Т.Цэрэндолгор
Шинжилгээг хянасан: БОШЛ-н ерөнхий инженер..... М.Аягүл

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

00013

УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,
2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983



БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2022 / № У35

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас
Дээжийн тодорхойлолт
Дээж авсан хүний нэр, албан тушаал
Дээжийн тоо, төрөл
Хүлээн авсан огноо
Дээжийн тодорхойлох үзүүлэлт
Шинжилгээ хийж дууссан огноо

"Бридж констракшин" ХХК
Сант сум
БОШЛ-ийн инженер М.Өнөржаргал
1, Ивэн голын ус
2022 - 10 - 28
гол ион, биогений элемент
2022 - 11 - 02

Стандартын дугаар	Шинжилгээ хийсэн элементүүд	Үр дүн	MNS 4586:1998
		Голын дунд хэсэг	
MNS ISO 10523:2001	РН -орчин	7.80	6.5-8.5
CA3 У21:2012	Өнгө	30.53	
MNS 1097.1970	Кальци	32.6	
MNS 1097:1970	Магни	19.8	
MNS ISO 7150:2008	Аммоны азот	0.21	1.5
MNS 4430:2005	Төмөр /нийт/	0.00	0.3
MNS 4424:2005	Хлор	2.1	350.0
MNS 6271:2011	Сульфат	47.0	100.0
MNS 6779:2019	Нитрит	0.007	0.02
MNS 6843:2020	Нитрат	0.37	9.0
MNS 6831:2020	Гидрокарбонат	137.3	
MNS ISO6059:2005	Хатуулаг	3.25	
MNS 6833:2020	Перманганатын исэлдэх чанар	4.2	
MNS 6272:2011	Фтор	0.67	0.7-1.5
MNS 1097:1970	Эрдэсжилт	239.6	
CA3 У 20:2012	Na+K	0.81	
MNS ISO 6878:2001	Фосфор	0.022	0.1
MNS ISO 7888:1999	ЕС, µs/cm	244.0	
	Булинггар	22.0	
MNS 6835:2020	Цахиур	1.22	
MNS ISO 11083:2001	Хрэм	илрээгүй	0.01

Дүгнэлт:

Сант сумын Ивэн багийн нутагт "Бридж констракшин" ХХК-ны усалтын систем хийгдэж буй орчмын голын ус MNS 4586:1998 стандарт дахь хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт үгүй байна.

Шинжилгээ хийсэн БОШЛ-ийн инженер
Шинжилгээг хянасан: БОШЛ-ийн ерөнхий инженер


М.Өнөржаргал
М.Аягүл

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

00014

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ**

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,
2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983.



БАЙГАЛЬ ОРЧНЫ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2022 / Х42	"Бридж констракшин" ХХК
Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	Сант сум
Дээжийн тодорхойлолт	БОШЛ-ийн ерөнхий инженер М.Аягүл
Дээж авсан хүний нэр, албан тушаал	1, Хөрс
Дээжийн тоо, төрөл	2022 - 10 - 28
Хүлээн авсан огноо	агрохимийн үзүүлэлт
Дээжийн тодорхойлох үзүүлэлт	MNS 3310:1991
Шинжилгээний аргын стандарт	2022 - 11 - 02
Шинжилгээ хийж дууссан огноо	

ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Дээж авсан цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд мг/кг							
		РН	ЕС	Фосфор	Сульфат	Чийг %	Нитрат	Аммоний азот	ялзмаг
1	Услалтын системийн ажил хийгдэж буй газрын орчим	6.72	37.1	12.16	124.3	1.10	10.9	66.48	1.00
	MNS 3297:2019 стандарт дахь ЗХД	6-9			160.0	-	130.0	-	-

Дүгнэлт:

Сант сумын Ивэн багийн нутагт "Бридж констракшин" ХХК-ны услалтын систем хийгдэж буй орчмын хөрс MNS 3297:2019 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт үгүй байна.

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер..... Т.Цэрэндолгор
Шинжилгээг хянасан: БОШЛ-н ерөнхий инженер..... М.Аягүл



Хуулбарлан хэвлэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

“Ивэн голын усалтын систем” төслийн 20үйл ажиллагааны зарим зураг







Иргэд болон мал гарахад зориулсан түр гарам



Галаас хамгаалах хэрэгсэл

